



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Г Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн, “Эх, нярайн эрүүл мэнд” стратегийн хэрэгжилтийг хангах, Баруун бүсийн аймгуудад хүүхдийн өвчлөл, эндэгдэл сүүлийн жилүүдэд буурахгүй, 2015 оны 1-р улирлын байдлаар өссөн дүнтэй байгааг харгалзан мэргэжил арга зүйн дэмжин, туслах үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай зэрэг Баруун бүсийн аймгуудын хүүхдийн өвчлөл, эндэгдлийн нөхцөл байдлыг үнэлэх, хүүхдийн эмч нарын оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, статистик бүртгэл мэдээллийн цогц сургалт зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөрийг хоёрдугаар, үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Баруун бүсийн эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн нөхцөл байдлын үнэлгээ, цогц сургалтыг Завхан аймагт зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Дэд сайд Д.Атармаа)-д үүрэг болгосугай.

3. Хүүхдийн эмч, эх, барих эмэгтэйчүүдийн эмч нарын оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах эмнэл зүйн болон удирдлагын багт зориулсан удирдлага, статистик бүртгэл мэдээллийн цогц сургалтын бэлтгэлийг хангаж, сургалт удирдах эмч-багш нарыг томилон ажиллуулахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ), Эмгэг, судлалын үндэсний төв (Г.Уянга)-д, сургалт, үнэлгээ хийх байр болон шаардлагатай бусад бэлтгэлийг хангахыг Завхан аймгийн Эрүүл мэндийн газар (Ч.Дэмчигсүрэн)-т тус тус даалгасугай.

4. Баруун бүсийн эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн нөхцөл байдлын үнэлгээ, цогц сургалтанд холбогдох эмч, мэргэжилтнүүдийнхээ ажлыг зохицуулж, шаардлагатай зардлыг шийдвэрлэн, оролцуулахыг Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Дээрхи цогц сургалтанд шаардлагатай санхүүжилтийг Эрүүл мэнд, спортын яамны бодлогын хүрээнд хийгдэх “Удирдах ажилтны сургалт”-ын зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга Ч.Бат-Эрдэнэд зөвшөөрсүгэй.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

080753

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
06 дугаар сарын 02-ны өдрийн 217
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт.



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч

Д.Атармаа, Эрүүл мэнд, спортын дэд сайд

Нарийн бичгийн дарга

С.Гантуяа, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн
мэргэжилтэн

Гишүүд

Э.Оюунсүрэн, Хяналт, шинжилгээ – үнэлгээ, дотоод
аудитын газрын даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч,

Л.Зэндмаа, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Н.Болормаа, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн
мэргэжилтэн


Р.Байгалмаа, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын мэргэжилтэн

Ш.Энхтөр, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний
төвийн захирал,

Ч.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
захирал,

Г.Уянга, Эмгэг судлалын үндэсний төвийн
захирал.

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
06 дугаар сарын 02-ны өдрийн 217 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт.



Ажлын удирдамж

Зорилго

Баруун бүсийн аймгуудын эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн шалтгаан, нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор тухайн аймгуудын сүүлийн жилүүдийн эндэгдлийн шалтгаан, эмчилгээ, тусламж үйлчилгээний стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийж, эмч нарын оношилгоо, эмчилгээний чадавхи, статистик бүртгэл мэдээллийг сайжруулах цогц сургалт зохион байгуулах, тусламж, үйлчилгээний удирдлага зохион байгуулалттай танилцан, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

Хамрагдах аймгууд

Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын Эрүүл мэндийн газрын дарга, Нэгдсэн эмнэлгийн дарга, Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, аймгийн нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмч, АНЭ-ийн нярайн эмч, Эрүүл мэндийн газрын статистикийн мэргэжилтэн.

Огноо: 2015 оны 6 дугаар сарын 9 – 13-ны өдрүүд.


Үйл ажиллагааны чиглэл

1. Баруун бүсийн аймгуудын эх, хүүхдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, 2012 – 2015 онуудын эх, хүүхдийн эндэгдлийн эмгэг судлалын материалыг нягтлан, хэлэлцэх,
2. Баруун бүсийн аймгуудын эх, хүүхдийн тусламж, үйлчилгээ, оношилгоо эмчилгээний стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх,
3. Хүүхдийн болон эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах эмнэл зүйн болон удирдлага, статистик бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох цогц сургалт зохион байгуулах.
4. “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж” хөтөлбөрийн дадлагажих сургалт зохион байгуулах,
5. Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, чанарыг сайжруулах, зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллах.

Оролцох аймгууд дараах бэлтгэлийг хангасан байна. Үүнд:

- Аймгийнхаа 2012-2014 он болон 2015 оны эхний улирлын эмгэг судлалын материал (эх, хүүхдийн эндэгдлийг дүгнэсэн протокол, эх, нярайн эндэгдлийн өвчний түүх),

- 2012-2014 он болон 2015 оны эхний улирлын эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийн статистик үзүүлэлтэд дүгнэлт хийсэн байх (хүүхдийн насны бүлгээр шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох),
- Эх, хүүхдийн яаралтай тусламж, үйлчилгээнд дутагдалтай байгаа тоног, төхөөрөмжийн жагсаалт гарган авчрах,
- Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр хийсэн хяналт – үнэлгээ, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн.



Хүлээгдэж буй үр дүн.

1. Баруун бүсийн аймгуудын эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийн нөхцөл байдалд үнэлгээ хийсэн байна.
2. Эмч, мэргэжилтнүүдийн оношлох, эмчлэх эмнэл зүйн ур чадвар сайжруулах сургалтууд зохион байгуулагдсан байна.
3. Удирдлага, зохион байгуулалт, статистик бүртгэл мэдээллийн чиглэлээр арга зүйн зөвлөмж гарна.

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
5 дугаар сарын 02-ны өдрийн 217 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт.

Завхан аймагт зохион байгуулах
үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр

Хугацаа	Үйл ажиллагааны	Хариуцах
Эхний өдөр:		
09.00 – 09.30	Баруун бүсийн аймгуудын “Хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах” зорилгоор зохион байгуулагдаж буй үнэлгээ, сургалтын нээлт <i>Д.Атармаа, Эрүүл мэнд, спортын сайд</i>	Ч.Дэмчигсүрэн, Завхан аймгийн ЭМГ-ын дарга
09.30 – 10.00	Баруун бүсийн аймгуудын Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн сүүлийн 3 жилийн байдал <i>Л.Зэндмаа, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга</i>	С.Гантуяа, ЭТХ Н.Болормаа, ЭТХ
10.00 – 10.30	Асуулт, хариулт	
10.30 – 11.00	Цайны завсарлага	
11.00 – 17.00	Баруун бүсийн аймгуудын эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн шалтгаан, нөхцөл байдлын үнэлгээ /Үнэлгээ 2 өдөр хийх ба хөтөлбөрийг тусад нь боловсруулах/	Э.Оюунсүрэн, ХШҮДАГ-ын дарга удирдан явуулна
2 дахь өдөр:		
09.00 – 18.00	Хүүхдийн эмч нарын оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах эмнэл зүйн сургалт /2 өдөр хийх ба хөтөлбөрийг тусад нь гаргана/	ЭХЭМҮТ
09.00 – 18.00	Статистик бүртгэл мэдээллийн цогц сургалт зохион байгуулах /2 өдөр хийх ба хөтөлбөрийг тусад нь боловсруулах/	ЭМХТ
3 дахь өдөр:		
09.00 – 16.00	Хүүхдийн эмч нарын оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах эмнэл зүйн сургалт /2 өдөр хийх ба хөтөлбөрийг тусад нь боловсруулах /	ЭХЭМҮТ
09.00 – 16.00	Статистик бүртгэл мэдээллийн цогц сургалт зохион байгуулах /2 өдөр хийх ба хөтөлбөрийг тусад нь боловсруулах /	ЭМХТ
16.00 – 18.00	Хаалт <i>Д.Атармаа, Эрүүл мэнд, спортын сайд Э.Оюунсүрэн, ХШҮДАГ-ын дарга</i>	